



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/248

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цагаан-Уул Сумын Засаг даргын 2024 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн 1/82 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлттэй холбоотой Завхан аймгийн Их-Уул сум, Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сум хоорондын хилийн цэсийн орчимд үүссэн газрын маргааны судалж танилцуулах, санал боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: М.Хуягбаатар- (Аймгийн Засаг даргын Орлогч)

Гишүүдэд: С.Гончигням- (Цагаан-Уул сумын Засаг дарга)

З.Нямбаяр- (Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газрын
Газрын удирдлагын хэлтсийн дарга)

Б.Бямба-Эрдэнэ- (Цагаан-Уул сумын Шарга багийн Засаг дарга)

А.Энхбаатар- (Цагаан-Уул сумын Газрын даамал)

А.Энхбаяр- (Цагаан-Уул сумын хэсгийн төлөөлөгч)

Т.Пүрэвхүү- (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Бэлчээр хариуцсан
мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Д.Чинзориг- (Аймгийн засаг даргын тамгын газрын Хөгжлийн
бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн
ахлах мэргэжилтэн)

2.Хууль тогтоомжийн хүрээнд үүссэн нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж, бэлчээрийн зөрчлийн талаар судалж, цаашид авах арга хэмжээний талаар танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Захирамж2024
6712010785